

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/293/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал:  
С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: [info@goldenpageaudit.mn](mailto:info@goldenpageaudit.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.25 № 01/87  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БОЛОВСРОЛ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН  
ДАРГА Ц.НАРАНТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Т Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Боловсролын ерөнхий хууль шинэчлэгдэн батлагдаж үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан, уян хатан тогтвортой, нээлттэй, насан туршийн суралцахуйг дэмжсэн, ардчилсан хүмүүнлэг ёсыг дээдэлсэн сахисан байх, боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтлах тэргүүлэх салбар байна гэж зарчмаа тодорхойлсон.

### Аудитын гол асуудал

Боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцахуйгаас эхэлнэ. Албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол гэсэн түвшинтэй байна. Иргэний амьдралын орчинд суралцахуйг хүлээн зөвшөөрч, үр

019020114

дүнг баталгаажуулж болно, албан болон албан бус боловсролын агуулга, стандартыг тогтооно.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Сургалтын цахим систем нэвтрүүлэх, зардал батлах тухай” А/312 дугаар тушаалаар олон улсад математикийн хичээлд туршилтаар баталгаажиж, үр дүн гарсан олон улсын жишигт нийцсэн Eduten цахим систем нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Гүйцэтгэлээр 7 үндсэн зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс үр дүнд хүрсэн 50, тодорхой үр дүнд хүрсэн 6, эрчимжүүлэх шаардлагатай 1 ажил хэрэгжиж гүйцэтгэл 92,45 хувьтай үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## **АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор Ерөнхий Боловсролын сургууль
БЕГ	Боловсролын Ерөнхий Газар

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>44,073,478.71</u></b>	<b><u>27,543,620.80</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	4,616,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	4,616,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,073,478.71	22,927,620.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	28,818,077.62	4,074,621.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,255,401.09	18,852,999.00
35410	Бичиг хэргийн материал	245,000.00	300,500.00
35420	Аж ахуйн материал	11,424,699.00	18,027,499.00
35440	Түлш, шатах тослох материал	2,760,000.00	525,000.00
35470	Бусад хангамжийн материал	825,702.09	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>575,685,855.95</u></b>	<b><u>557,624,164.81</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	575,685,855.95	557,624,164.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	559,629,957.56	541,687,196.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	429,901,696.02	429,901,696.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(43,616,282.68)	(57,477,668.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,600,000.00	81,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,360,000.00)	(40,880,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,301,254.40	165,716,140.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,178,423.45)	(56,663,122.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,536,877.00	26,448,483.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,555,163.73)	(6,958,332.21)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,055,898.38	15,936,968.42
39301	Програм хангамж	594,650.00	594,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(138,751.62)	(257,681.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,600,000.00	15,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>619,759,334.66</u></b>	<b><u>585,167,785.61</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>619,759,334.66</u></b>	<b><u>585,167,785.61</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	619,759,334.66	585,167,785.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	720,601,014.08	720,601,014.08
51101	Өмч: - төрийн	720,601,014.08	720,601,014.08
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(128,766,960.04)	(164,035,689.09)
51210	Өмнөх үеийн үр дүн	(167,698,290.73)	(129,444,140.04)
51220	Тайлант үеийн үр дүн	38,931,330.69	(34,591,549.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,925,280.62	28,602,460.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>619,759,334.66</u></b>	<b><u>585,167,785.61</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,160,616,108.75</b>	<b>4,288,666,837.29</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>297,762,133.75</b>	<b>273,448,988.29</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	297,762,133.75	273,448,988.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	297,762,133.75	273,448,988.29
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	297,762,133.75	273,448,988.29
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,862,853,975.00</b>	<b>4,015,217,849.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,804,075,900.00	3,916,418,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,804,075,900.00	3,916,418,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	58,778,075.00	98,683,149.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	22,871,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800,000.00	23,412,903.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,478,075.00	37,486,446.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500,000.00	15,028,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,121,684,778.06</b>	<b>4,322,160,820.11</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,121,684,778.06</b>	<b>4,322,160,820.11</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	767,568,936.45	1,086,878,742.90
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	315,043,830.14	534,643,268.79
210101	Үндсэн цалин	218,309,832.74	273,554,849.71
210102	Нэмэгдэл	52,071,520.20	174,143,397.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,397,000.00	31,118,031.10
210104	Урамшуулал	15,265,477.20	55,826,990.43
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,623,200.28	66,184,281.00
210201	Тэтгэврийн даатгал	26,757,143.08	45,888,761.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,147,899.19	5,156,890.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,518,319.35	4,181,052.93
210204	Ажилгүйдлийн даатгал	562,037.02	1,001,457.05
210205	Эрүүл мэндийн даатгал	5,637,801.64	9,956,119.69
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,463,990.97	62,775,041.50
210301	Гэрэл, цахилгаан	1,135,402.97	2,403,700.76
210302	Түлш, халаалт	51,177,131.00	57,788,672.74

210303	Цэвэр, бохир ус	2,151,457.00	2,582,668.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	238,681,012.28	279,029,904.50
210401	Бичиг хэрэг	2,840,097.00	2,001,550.00
210402	Тээвэр, шатахуун	4,211,460.00	5,460,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	417,080.00	382,426.00
210404	Ном, хэвлэл	144,300.00	16,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	460,010.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,546,020.00	1,139,050.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,590,210.17
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	228,062,045.28	267,080,508.33
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	833,050.00	2,038,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	808,500.00
210604	Урсгал засвар	833,050.00	1,229,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,648,900.00	8,578,000.00
210702	Дотоод албан томилолт	8,648,900.00	8,578,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,724,325.00	474,210.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,724,325.00	474,210.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	108,550,627.78	133,155,787.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,891,928.00	5,945,620.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,738,643.00	67,551,864.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,920,056.78	59,658,302.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,354,115,841.61	3,235,282,077.21
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,281,393,405.00	3,180,266,350.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,376,692,805.00	1,906,144,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,904,400,600.00	1,273,327,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	794,250.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	72,722,436.61	55,015,727.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,722,436.61	55,015,727.21
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>38,931,330.69</u></b>	<b><u>(33,493,982.82)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,097,566.23
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,097,566.23
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(1,097,566.23)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>38,931,330.69</u></b>	<b><u>(34,591,549.05)</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>3,862,853,975.00</u></b>	<b><u>4,015,217,849.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,862,853,975.00</b>	<b>4,015,217,849.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,804,075,900.00	3,916,418,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,804,075,900.00	3,916,418,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	58,778,075.00	98,683,149.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	22,871,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800,000.00	23,412,903.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,478,075.00	37,486,446.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500,000.00	15,028,000
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>3,862,853,975.00</u></b>	<b><u>4,015,217,849.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,862,853,975.00</b>	<b>4,015,217,849.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>508,738,133.39</b>	<b>775,319,771.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	315,043,830.14	534,643,268.79
210101	Үндсэн цалин	218,331,423.13	273,554,849.71
210102	Нэмэгдэл	52,071,520.20	174,143,397.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,397,000.00	31,118,031.10
210104	Урамшуулал	15,243,886.81	55,826,990.43
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,623,200.28	66,184,281.00
210201	Тэтгэврийн даатгал	26,757,143.08	45,888,761.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,147,899.19	5,156,890.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,518,319.35	4,181,052.93
210204	Ажилгүйдлийн даатгал	562,037.02	1,001,457.05
210205	Эрүүл мэндийн даатгал	5,637,801.64	9,956,119.69
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,463,990.97	62,775,041.50
210301	Гэрэл, цахилгаан	1,135,402.97	2,403,700.76
210302	Түлш, халаалт	51,177,131.00	57,788,672.74
210303	Цэвэр, бохир ус	2,151,457.00	2,582,668.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,104,767.00	6,861,336.00
210401	Бичиг хэрэг	2,349,697.00	1,626,950.00
210402	Тээвэр, шатахуун	6,181,460.00	3,225,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	417,080.00	382,426.00
210404	Ном, хэвлэл	144,300.00	16,160.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	460,010.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,552,220.00	1,250,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,130,300.00</b>	<b>23,061,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	19,998,100.00
210604	Урсгал засвар	1,130,300.00	3,063,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,648,900.00</b>	<b>8,578,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,648,900.00	8,578,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,724,325.00</b>	<b>474,210.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,724,325.00	474,210.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,998,820.00</b>	<b>72,741,734.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,290,177.00	4,554,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,708,643.00	68,186,964.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,354,115,841.61</b>	<b>3,239,898,077.21</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,281,393,405.00</b>	<b>3,180,266,350.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,376,692,805.00	1,906,144,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,904,400,600.00	1,273,327,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	794,250.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>72,722,436.61</b>	<b>59,631,727.21</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,722,436.61	59,631,727.21
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	(167,698,290.73)	580,828,003.97
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	(167,698,290.73)	580,828,003.97
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	38,931,330.69	38,931,330.69
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	(128,766,960.04)	619,759,334.66
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	(128,766,960.04)	619,759,334.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(677,180.00)	(677,180.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	720,601,014.08	27,925,280.62	(129,444,140.04)	619,082,154.66
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	677,180.00	-	677,180.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,591,549.05)	(34,591,549.05)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	720,601,014.08	28,602,460.62	(164,035,689.09)	585,167,785.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,916,418,700.00	3,861,498,404.29	54,920,295.71	98.60
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,916,418,700.00	3,861,498,404.29	54,920,295.71	98.60
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	698,673,800.00	681,732,054.29	16,941,745.71	97.58
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	521,130,400.00	514,701,272.79	6,429,127.21	98.77
210101	Үндсэн цалин	274,190,000.00	273,554,849.71	635,150.29	99.77
210102	Нэмэгдэл	157,443,100.00	154,201,401.55	3,241,698.45	97.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396,000.00	31,118,031.10	2,277,968.90	93.18
210104	Урамшуулал	56,101,300.00	55,826,990.43	274,309.57	99.51
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	73,081,300.00	63,713,374.00	9,367,926.00	87.18
210201	Тэтгэврийн даатгал	52,682,200.00	44,193,680.14	8,488,519.86	83.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,099,800.00	4,957,456.19	142,343.81	97.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,079,800.00	3,965,764.89	114,035.11	97.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,000.00	963,552.05	56,447.95	94.47
210205	Эрүүл мэндийн даатгал	10,199,500.00	9,632,920.73	566,579.27	94.45
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,505,500.00	62,775,041.50	730,458.50	98.85
210301	Гэрэл, цахилгаан	7,420,900.00	2,403,700.76	5,017,199.24	32.39
210302	Түлш, халаалт	53,683,200.00	57,788,672.74	(4,105,472.74)	107.65
210303	Цэвэр, бохир ус	2,401,400.00	2,582,668.00	(181,268.00)	107.55
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,013,200.00	6,611,336.00	401,864.00	94.27
210401	Бичиг хэрэг	1,627,000.00	1,626,950.00	50.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,978,500.00	2,975,000.00	3,500.00	99.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	404,800.00	382,426.00	22,374.00	94.47
210404	Ном, хэвлэл	71,200.00	16,160.00	55,040.00	22.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,900.00	360,000.00	320,900.00	52.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250,800.00	1,250,800.00	-	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,063,800.00	23,061,900.00	1,900.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,998,100.00	1,900.00	99.99
210604	Урсгал засвар	3,063,800.00	3,063,800.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,026,900.00	2,024,000.00	2,900.00	99.86
210702	Дотоод албан томилолт	2,026,900.00	2,024,000.00	2,900.00	99.86
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	477,200.00	474,210.00	2,990.00	99.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	477,200.00	474,210.00	2,990.00	99.37
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,375,500.00	8,370,920.00	4,580.00	99.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,555,100.00	4,554,770.00	330.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,820,400.00	3,816,150.00	4,250.00	99.89

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,217,744,900.00	3,179,766,350.00	37,978,550.00	98.82
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,217,744,900.00	3,179,766,350.00	37,978,550.00	98.82
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,932,986,300.00	1,906,144,700.00	26,841,600.00	98.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,284,437,100.00	1,273,327,400.00	11,109,700.00	99.14
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	294,250.00	27,250.00	91.52
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,916,418,700.00	3,861,498,404.29	54,920,295.71	98.60
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,916,418,700.00	3,861,498,404.29	54,920,295.71	98.60
122005	Орон нутгийн төсвөөс	3,916,418,700.00	3,861,498,404.29	54,920,295.71	98.60
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	65.00	55.00	10.00	84.62
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	32.00	27.00	5.00	84.38
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	16.00	5.00	76.19
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>32.00</b>	<b>27.00</b>	5.00	84.38
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	22.00	17.00	5.00	77.27

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,958,993.00	98,799,149.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,958,993.00	98,799,149.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,958,993.00	93,587,717.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	19,941,996.00
210102	Нэмэгдэл	-	19,941,996.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,470,907.00
210201	Тэтгэврийн даатгал	-	1,695,081.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	199,434.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	215,288.04
210204	Ажилгүйдлийн даатгал	-	37,905.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	323,198.96
2104	Хангамж, бараа материалын зардал	4,187,000.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,187,000.00	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,594,000.00	6,554,000.00
210702	Дотоод албан томилолт	8,594,000.00	6,554,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,177,993.00	64,370,814.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,177,993.00	64,370,814.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,082.00	4,711,431.50
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,082.00	4,711,431.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,778,075.00	98,683,149.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,778,075.00	98,683,149.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	22,871,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800,000.00	23,412,903.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,478,075.00	37,486,446.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500,000.00	15,028,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн, боловсрол, соёлын тогтвортой хөгжлийг хангаж, ЕБС, цэцэрлэг, соёл урлагийн болон бусад байгууллага, иргэдэд тасралтгүй, чанартай үйлчилгээг үзүүлэхэд оролцдог чиг үүрэг бүхий Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 27 сумын СӨБ-ын 41 бүлэг, МСҮТ-ийн 4, ЕБС-ын 31 сургуулийн багш, сурагч, эцэг, эхтэй шууд болон шууд бусаар хамтран ажиллаж үйл ажиллагаа явуулдаг байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь захиргааны нэгж, мэргэжил арга зүйн нэгж, үйлчилгээний нэгж гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга 1, ахлах мэргэжилтэн 5, мэргэжилтэн 11, үйлчилгээний ажилтан 10 нийт 27 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,591.5 мянган төгрөгөөр буюу 5,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	4,616.0	4,616.0
Бараа материал	44,073.5	22,927.6	(21,145.9)
Үндсэн хөрөнгө	575,685.9	557,624.2	(18,061.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>619,759.3</b>	<b>585,167.8</b>	<b>(34,591.5)</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	619,759.3	585,167.8	(34,591.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>619,759.3</b>	<b>585,167.8</b>	<b>(34,591.5)</b>

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Авлага 4,616.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайланд онд үүссэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,145.9 мянган төгрөгөөр буурсан нь 2,590.2 мянган төгрөгийн бараа материал акталж, БЕГ-аас шилжүүлсэн хангамжийн материалыг хуваарийн дагуу сургууль, цэцэрлэгийн харьяа байгууллагуудад шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 18,061.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд шинээр 15,673.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, МХГ-аас 892.6 мянган төгрөг шилжүүлэн авсан, аймгийн Засаг даргын хөрөнгө оруулалтаар 9,288.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч 34,269.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж элэгдлээрээ буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс урсгал санхүүжилтээр 550,350.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн санхүүжилтээр 3,255,532.1 мянган төгрөгөөр тооцон нийт 3,805,882.5 мянган төгрөгийг төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсийг 146,806.1 мянган төгрөг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 17,704.5 мянган төгрөгөөр өсгөж, хангамжийн материалын зардлыг 6,848.7 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 3,169.0 мянган төгрөгөөр буурч баталсан байна. Энэ нь Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын төсвийн төслийг өсгөсөн нь албан хаагчдын цалинд өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 189,722.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төрийн захиргааны албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл 22,412.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон байна.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 22,412.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг төрийн захиргааны албан хаагчдын цалинд олгосон байна. Гэрэл цахилгааны зардлыг 5,017.1 мянган төгрөгийг дутуу зарцуулсан бол түлш халаалтын зардалд 4,105.4, цэвэр бохир усны зардалд 181.2 төгрөгийг тус тус илүү зарцуулсан нь зардал бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байгаатай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биел элт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол				
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,009,263.0	1,014,960.20	(5,697.2)	100.6
3	71802 Ерөнхий боловсрол				
4	71808 Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага				
5	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	698,673.80	681,732.05	16,941.7	97.6
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	321,500.00	294,250.00	27,250.0	91.5
7	70207 Гадаадын зээл тусламж				
8	80104 Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил	86,075.35	79,805.10	6,270.2	92.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 37,486.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 23,412.9 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 22,871.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон нэмэлт орлого 14,912.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого 116.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн нэмэгдэл цалин, шимтгэлд 22,413.6 мянган төгрөг, тээвэр шатахуунд 250.0 мянган төгрөг, албан томилолтод 6,554.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 64,370.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж 500.0 мянган төгрөг тус тус зарцуулж 4,711.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний зардал, урсгал засвар, бичиг хэрэг, шуудан холбоо, гэрэл цахилгаан, тээвэр шатахууны зардлуудад 56,333.0 мянган төгрөгөөр төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 114,485.2 мянган төгрөг зарцуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, он дамжсан авлага, өр төлбөрийг даруй барагдуулах, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,450,363.7 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 36,755.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар 48.5 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн бүрэн хэрэгжсэн байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,286.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснийг зөвлөмж өгснийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	15,286.0	3	15,286.0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>15,286.0</b>	<b>3</b>	<b>15,286.0</b>	<b>100</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал Боловсролын хуулийн шинэчлэлтийг хэрэгжүүлэн ажиллахдаа цэцэрлэг сургуулийн төсвийн шууд захирагч нартай байгуулсан гэрээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, төсвийн

төлөвлөлт үндэслэлтэй эсэх, өөр байгууллага байр ашиглалтын зардал төлдөг эсэхийг авч үзэх шаардлагатай болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 20,007.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илэрч 20,007.5 мянган төгрөгийн 2 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу авдаг байх, төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулдаг байх.

#### **2. Өглөгийн талаар холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2021 оны агаарын бохирдлын төлбөр 7.5 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах, аудитын батламж мэдэгдлийн оршин байх "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлөвлөөгүй худалдан авалт хийсэн	1	20,000.0					1	20,000.0				
Өглөг тайлагнаагүй ертэй гарсан.	1	7.5					1	7.5				
Дүн	1	20,007.5					1	20,007.5				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроосон 4 мэдээлэл байршуулаагүй	1						1	
Дүн	1						1	